



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 680

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, 2022 оны 293 дугаар тогтоолын 3.4, 5.2 дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Гадаад харилцааны яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 682,000,000.00 (зургаан зуун наян хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 170,032,876.74 (нэг зуун далан сая гучин хоёр мянга найман зуун далан зургаан төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий биет бус хөрөнгийг (www.evisa.mn) хавсралтад заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
680 дугаар тогтоолын хавсралт

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН ГАЗРЫН БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Консулын цахим виза бүртгэлийн програм	2021.12.01	682,000,000.00	170,032,876.74	511,967,123.26
	НИЙТ ДҮН		682,000,000.00 (зургаан зуун наян хоёр сая)	170,032,876.74 (нэг зуун далан сая гучин хоёр мянга найман зуун далан зургаан төгрөг далан дөрвөн мөнгө)	511,967,123.26 (таван зуун арван нэгэн сая есөн зуун жаран долоон мянга нэг зуун хорин гурван төгрөг хорин зургаан мөнгө)